15 "Найнги" ХХК-ийн захиалгаар Адуунчулууны нүүрсний ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээлт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан "ШУТИС-ийн Уул уурхайн төсөл судалгааны төв" нь хариуцах бөгөөд түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч П Цэндпүрэв нар хариуцах.

16. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж, ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэй.

17. Захиалагч компани Техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах тухай Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гарснаас хойш 5 хоногт багтаан Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дарга гаргасан шийдвэрээ түдгэлзүүлэх, цуцлах эрхтэйг анхааруулах нь зүйтэй.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмал, газрын тосны газрын даргад Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн "Дорнод аймгийн Хэрлэн, Баянтүмэн сумдын нутагт орших MV-001364 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Адуунчулууны нүүрсний ордыг ашиглах техник - эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хэлэлцсэн тухай"-ийг хүлээн авах шийдвэр гаргахыг үлэмжлэхээр шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:


ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

Б. МӨНХТӨР

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
САЛБАР ХУРАЛДААНЫ ДАРГА  Б. ДЭЛГЭРЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Э БОЛД-ЭРДЭНЭ

УБМЗ-ийн Т/19.16.01 дугаар 1 нэгдлийн хавсралт

Дорнод аймгийн Хэрлэн, Баянтүмэн сумын нутагт орших Адуунчулууны нүүрсний и.г. уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн

Тоолооны нэгтгэл

Тусгай зөвшөөрлийн дугаар МУ-001364

Д/д	Блокын дугаар													Нийт		
	I-сологийн нөөц						Үйлдвэрийн нөөц						Хяналт		Болроод	Нийт
	Эдийн засгийн үр ашигтай нөөц						2019-01-01 байдлаар									
А	В	С	Найт (А-В-С)	А	В	С	Найт (А-В-С)	А	В	С	Найт (А-В-С)	Хувь	Хэмжээ	Хувь	Хэмжээ	Мил.тн
Мил.тн	Мил.тн	Мил.тн	Мил.тн	Мил.тн	Мил.тн	Мил.тн	Мил.тн	Мил.тн	Мил.тн	Мил.тн	Мил.тн	%	Мил.тн	%	Мил.тн	Мил.тн
1	16,437.94	-	-	16,437.94	3,837.47	-	3,837.47	3,837.47	-	-	3,837.47	4.86	3,837.47	2.13	87.50	3,837.47
2	1,335.11	-	-	1,335.11	-	1,109.70	1,109.70	-	1,109.70	-	1,109.70	8.27	1,109.70	6.83	28.33	1,109.70
Нийт	16,437.94	1,335.11	-	17,773.05	3,837.47	1,109.70	4,947.17	3,837.47	1,109.70	-	4,947.17	4.60	4,947.17	2.13	112.80	4,837.22

Танилцуулсан: АМТ-ын НСХ-ийн мэргэжилтэн Г. Гөрмөнх

Тооцоог хийсэн: Уул уурхайн төсөл судалгааны товчийн инженер Ц.Амарсайхан



ДААТГАЛ

Гүйцэтгэх захирлын 2020 оны 6 сарын 29 өдрийн
А/20/73 тоот тушаалын хавсралт

Ард Санхүүгийн Нэгдлийн байр 2-р давхар, Ерөнхий
сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот 14200, Монгол улс
Утас: + (976) 7720 0088
И-Мэйл: info@arddaatgal.mn
Вэб: www.arddaatgal.mn

ДААТГАЛЫН ГЭРЭЭ

Гэрээний дугаар: D232079001

Даатгалын гэрээний огноо:


2023 оны 05 р сарын 12 ны өдөр

БАТЛАВ:

АРД ДААТГАЛ ХК
ДОРНОД САЛБАРЫН ЗАХИРАЛ Т.ПҮРЭВСҮРЭН

БАТЛАВ:

НАЙНГИ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.БЯМБАСҮРЭН



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Даатгагчийн нэр:	АРД ДААТГАЛ ХК
Даатгуулагчийн нэр:	Найнги ХХК
Даатгуулагчийн хаяг:	Хаяг:Хэрлэн сум 6-р баг өөрийн байр Утас: 99112350
Даатгуулагчийн үйл ажиллагаа:	Уул уурхай
Даатгалын гэрээний дугаар:	D232079001
Даатгалын гэрээний хугацаа:	2023 оны 05 дугаар сарын 12 -ны өдрийн 00 цагаас 2024 оны 05 дугаар сарын 11 -ны өдрийн 24 цаг хүртэл хүчин төгөлдөр байна.
Даатгалын төрөл:	1) Гэнэтийн ослын даатгал – Бүлэг I
Даатгалын нийт үнэлгээ:	112,000,000 төгрөг
Даатгалын нийт хураамж:	1,120000 төгрөг
Даатгалын гэрээ үйлчлэх нутаг дэвсгэр:	Монгол Улс
Давхар даатгагч:	Hannover Re..
Даатгалын хураамж төлөх хугацаа:	Даатгалын гэрээ батлагдсанаас хойш ажлын 5 хоногт

ДААТГАЛЫН ГЭРЭЭ

Нэг талаас 2062089 тоот регистрийн дугаартай АРД ДААТГАЛ ХК (цаашид Даатгагч гэх)-ийг төлөөлж Б.Оюунтунгалаг, нөгөө талаас 2010895 тоот регистрийн дугаартай Найнги ХХК –г төлөөлж Б.Солонго (цаашид Даатгуулагч гэх) нар дор дурдсан даатгалын гэрээг харилцан тохиролцож дараах нөхцөлтэйгөөр байгуулав.

ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.1.1. **Даатгагч** гэж Даатгалын тухай хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, Монгол улсын хуулийн этгээд болох Ард Даатгал ХК-ийг;
 - 1.1.2. **Даатгуулагч** гэж өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;
 - 1.1.3. **Даатгалын зүйл** гэдэгт эд хөрөнгө, иргэдийн амь нас, эрүүл мэнд, түүнчлэн хуульд харшлаагүй эдийн бус ашиг сонирхлыг;
 - 1.1.4. **Даатгалын эрсдэл** гэдэгт даатгалд хамрагдсан зүйлд хохирол учруулж болох нөхцөл, орчныг;
 - 1.1.5. **Даатгалын тохиолдол** гэж даатгуулсан зүйлд даатгалын эрсдэлийн улмаас учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;
 - 1.1.6. **Даатгалын хураамж** гэж даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;
 - 1.1.7. **Даатгалын нөхөн төлбөр** гэж гэрээний дагуу даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгалын зүйлд учирсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор даатгагчаас даатгуулагчид олгох мөнгө эсвэл биет зүйлийг;
 - 1.1.8. **Даатгалын үнэлгээ** гэж даатгуулж байгаа эд хөрөнгийн болон эдийн бус ашиг сонирхлын мөнгөн илэрхийллийн хэмжээг;
 - 1.1.9. **Бүрэн сүйрэл** гэдэгт даатгалын зүйл нөхөн сэргээгдэх, засварлагдах боломжгүй буюу нөхөн сэргээгдэх зардал нь даатгалын үнэлгээнээс хэтэрсэн байх нөхцөл байдлыг;
 - 1.1.10. **Өөрийн хүлээх хариуцлага** гэж даатгалын тохиолдлоос үүссэн хохиролд даатгагчийн олгох нөхөн төлбөрөөс хасагдах хэмжээ буюу даатгуулагчийн хариуцах мөнгөн төлбөрийн хэмжээ;
 - 1.1.11. **Нөхөн сэргээх зардал** гэж даатгалын зүйл нөхөн сэргээгдэх, засварлагдахад гарах шууд зардлыг;
 - 1.1.12. **Шууд бус зардал** гэж даатгалын тохиолдол бий болсны улмаас даатгалын зүйлийг сэргээн засварлахтай холбогдон гарах нөхөн сэргээх зардлаас бусад зардлыг;
 - 1.1.13. **Ерөнхий мэдээлэл нь** даатгалын гэрээний салшгүй хэсэг бөгөөд даатгалын гэрээтэй холбоотой мэдээллийг хураангуйлан харуулсан байна.
 - 1.1.14. **Элэгдэл** гэж даатгалын зүйл нь хэвийн ашиглалтын явцад зөвхөн хугацаанаас хамааран хорогдсон өртгийг;
 - 1.1.15. **Хүндэтгэн үзэх шалтгаан** гэж Даатгуулагчаас өөрөөс нь үл хамаарах урьдчилан мэдэх боломжгүй гэнэтийн нөхцөл байдалд орсон болон холбогдох бусад хуульд заасан нөхцөл байдлыг;

(D232079001)___ / Ард даатгал ХК /

- 1.1.16. **Нэр даруй** гэж тухайн үйл явдал болсон, болж өнгөрсөн цаг мөчийг хэлэх ба хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд тухайн тохиолдлыг мэдэгдэх боломжтой ердийн хугацааг;
- 1.1.17. **Буруутай этгээд** гэж даатгалын тохиолдол болох нөхцөл орчныг бүрдүүлсэн нь эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдсон, эсвэл гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээдийг;

ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 2.1. Энэхүү гэрээгээр нэг талаас даатгуулагч нь даатгалын гэрээнд болон түүний хавсралтад дурдсан даатгалын зүйлийг гэрээний тусгай нөхцөлд заасан даатгалын хэлбэрээр даатгуулж даатгалын хураамж төлөх, нөгөө талаас даатгагч нь даатгалын тохиолдол болсон нөхцөлд даатгалын зүйлд учирсан хохирлыг даатгуулагчид нөхөн төлөх харилцааг зохицуулна.
- 2.2. Хоёр тал энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 2.3. Энэхүү гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлүүд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд талууд гэрээний тусгай нөхцөлийг баримтална.

ГУРАВ. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1. Энэхүү гэрээ нь “Ерөнхий мэдээлэл” -д заасан хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 3.2. Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
 - 3.2.1. Хууль болон даатгалын гэрээгээр тогтоосон хугацаа дууссан;
 - 3.2.2. Даатгагч эсхүл даатгуулагч дампуурсан, татан буугдсан;
 - 3.2.3. Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тогтоосон;
 - 3.2.4. Даатгагдсан хөрөнгө шүүхийн шийдвэрээр хураагдсан;
 - 3.2.5. Даатгалын хугацааг гэрээнд зааснаас өмнө дуусгавар болгохоор талууд тохиролцсон;
 - 3.2.6. Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;

ДӨРӨВ. ДААТГАГЧИЙН ЭРХ

- 4.1. Даатгуулагчийн эрх, үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих;
- 4.2. Даатгуулагчаас хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, биелүүлээгүй тохиолдолд гэрээг цушлах болон түүнд өөрчлөлт оруулах санал тавих;
- 4.3. Даатгалын зүйлийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж танилцах;
- 4.4. Даатгуулагч аюулыг санаатайгаар ихэсгэсэн бол даатгагч гэрээг цушлах саналыг нөгөө талд тавих;
- 4.5. Даатгалтай холбоотой шаардлагатай гэж үзсэн мэдээллийг даатгуулагчаас бүрэн хэмжээгээр гаргуулах;
- 4.6. Хууль болон гэрээнд заасан үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн нөхөн төлөхөөс татгалзах;

ТАВ. ДААТГАГЧИЙН ҮҮРЭГ

- 5.1. Даатгалын хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг даатгуулагчид танилцуулах;
- 5.2. Монгол Улсын хуульд зааснаас бусад тохиолдолд даатгуулагчийн талаарх мэдээ, материалын нууцыг хадгалах, бусдад дамжуулахгүй байх;

(D232079001) / Ард даатгал ХК /

- 5.3. Даатгалын тохиолдол бий болсны улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгахын төлөө даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгуулагчид нөхөн төлөх;
- 5.4. Хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох зорилгоор Даатгуулагчтай бүх талаар идэвхтэй хамтран ажиллах;
- 5.5. Даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг гэрээгээр тохирсон хугацаа, хэмжээнд шийдвэрлэх;

ЗУРГАА.ДААТГУУЛАГЧИЙН ЭРХ

- 6.1. Даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;
- 6.2. Даатгагчийг хууль болон гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах;
- 6.3. Даатгуулагчийн эрх үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид тавих;
- 6.4. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Даатгагчаас түүний бизнесийн нууцад үл хамаарах даатгагчийн санхүүгийн чадавхын талаар холбогдох мэдээ, мэдээлэл шаардах;
- 6.5. Хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох зорилгоор Даатгагчтай бүх талаар идэвхтэй хамтран ажиллах;
- 6.6. Даатгалын тохиолдлын шалтгаан, нөхцөл, хохирлын хэмжээг үнэн зөв тогтоолгохын тулд эрх бүхий мэргэжлийн байгууллагад хандаж акт тогтоолгох;

ДОЛОО.ДААТГУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

- 7.1. Даатгалын хураамжийг гэрээгээр тохирсон хугацаанд багтаан даатгагчид төлнө.
- 7.2. Даатгалын тухай хууль тогтоомж, гэрээний нөхцөлтэй сайтар танилцах;
- 7.3. Даатгалын зүйлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг гэрээний хавсралтаар даатгагчид гаргаж өгөх;
- 7.4. Даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой арга хэмжээ авах;
- 7.5. Хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд Даатгалын тохиолдлыг даатгагчийн шуурхай албаны 77200088 утас болон имэйлээр нэн даруй мэдэгдэх;
- 7.6. Даатгалын тохиолдлын талаар даатгагчид мэдэгдсэнээс хойш шаардлагатай бүх материалыг 90 хоногийн дотор хүлээлгэн өгөх;
- 7.7. Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж байгаа аюул учруулах буюу даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдал, түүнчлэн гэрээ байгуулснаас хойш бий болсон нөхцөл байдал болон даатгалын тохиолдол бий болох таагүй нөхцөл орчин бүрдсэн тухай даатгагчид нэн даруй мэдээлэх үүрэгтэй.
- 7.8. Даатгалын зүйлийн өмчлөл, эзэмшилд өөрчлөлт орсон талаар даатгагчид ажлын 15 хоногт багтаан мэдэгдэж гэрээнд өөрчлөлт хийлгүүлэх;
- 7.9. Даатгалын зүйлийг бусдад түрээслэх, барьцаалуулах, зээлдүүлэх, ашиглуулах, тээвэрлэх үед тухай бүр нь даатгагчид мэдэгдэх;

НАЙМ. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 8.1. Даатгалын нөхөн төлбөрийг дараах материалыг үндэслэн шийдвэрлэнэ. Үүнд:
 - 8.1.1. Даатгуулагчийн өргөдөл эсвэл хүсэлт
 - 8.1.2. Даатгалын гэрээ, даатгалын баталгааны хуулбар эсвэл эх хувь;
 - 8.1.3. Даатгалын тохиолдол бий болсныг нотлох фото зураг, хэргийн газар дээрээс баталгаажуулсан бусад нотлох баримтууд, эд мөрийн баримтууд;
 - 8.1.4. Хохирлын шалтгаан, хэмжээ, зүйлийг эрх бүхий байгууллагаас тодорхойлсон акт;
 - 8.1.5. Эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлт, тодорхойлолт, хохирлын үнэлгээ, шүүхийн шийдвэр;

(1232079001) / Ард даатгал ХК /

- 8.1.6. Шаардлагатай бусад материал;
- 8.2. Гэрээнд заасан даатгалын эрсдэл даатгалын зүйлд учирвал, даатгагч нөхөн төлбөр олгохоос татгалзах үндэслэлгүй тохиолдолд “гэрээний үндсэн болон тусгай нөхцөл”-д заасны дагуу тооцоолол хийж, мөнгө эсвэл биет зүйлийн аль ч хэлбэрээр нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ.
- 8.3. Хохирлын хэмжээг тогтооход даатгуулагчийн гаргуулсан үнэлгээг харгалзаж үзэх ба даатгагч үнэлгээг үндэслэлгүй гэж үзвэл даатгуулагчтай зөвшилцөх, эс тохиолдолд хөндлөнгийн этгээдээр хохирлын үнэлгээ хийлгэнэ. Талууд хохирлын үнэлгээг тохиролцоогүй бол Монголын хохирол үнэлгээчдийн холбоонд хандаж үнэлгээ тогтоолгох, эс тохиолдолд шүүхэд хандана. Хохирлыг дахин үнэлүүлэхтэй холбогдсон зардлыг талууд тэнцүү харуцна.
- 8.4. Энэхүү гэрээнд заасан хугацаанаас хойш хүндэтгэн үзэх шалтгаантай 15 хоногийн дотор Даатгуулагч даатгалын хураамжаа төлөөгүй байх үед даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгалын нөхөн төлбөрийг гэрээнд заагдсан хувь хэмжээгээр нөхөн төлөх эсэхийг даатгагч дангаар шийдэх ба хэрэв шийдвэл уг нөхөн төлбөрөөс төлбөл зохих нийт даатгалын хураамжийг суутган тооцно. Суутгалын дараа төлөгдөөгүй үлдсэн даатгалын хураамжийг хэрхэн төлөх талаар гэрээний талууд харилцан тохиролцоно.
- 8.5. Даатгалын тохиолдол болсон үед Даатгагчийн нөхөн төлбөр хариуцсан албан тушаалтан нөхөн төлбөрийн баримтуудыг бүрэн гэж хүлээн авч, зохих баримт үйлдсэн өдрөөс хойш ажлын 14 өдрийн дотор хууль болон энэхүү гэрээгээр тохиролцсон хэмжээнд шийдвэрлэнэ. Хэрэв талууд нөхөн төлбөрийн хэмжээг харилцан тохиролцоогүй тохиолдолд энэхүү хугацааг ажлын 10 өдөр хүртэлх хугацаагаар сунгаж болно.
- 8.6. Хэрэв нөхөн төлбөрийн бүрдүүлсэн баримтыг нягталж шалгах явцад нэмэлт материал шаардлагатай болсон тохиолдолд гэрээний 8.5 –д заасан хугацаа нь тухайн материалыг хүлээн авсан өдрөөс хойш дахин тооцогдоно.
- 8.7. Хэрэв даатгалын нөхөн төлбөртэй холбоотойгоор тухайн хэрэг төрийн захиргааны байгууллагад хянагдаж байгаа, шүүхийн журмаар хянан хэлэлцэгдэж байгаа нөхцөлд, мөн Даатгагч давхар даатгалын гэрээний дагуу нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдол энэхүү гэрээний 8.5 дугаар зүйлд заасан зохицуулалт үйлчлэхгүй.
- 8.8. Даатгагчаас даатгуулагчид олгох нөхөн төлбөр болон хохирол бууруулах үйл ажиллагааны зардлын нийлбэр нь даатгалын үнэлгээнээс хэтэрч үл болно.
- 8.9. Даатгалын тохиолдол бий болсны дараа даатгагч нөхөн төлбөрийг олгосон нөхцөлд буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.
- 8.10. Даатгуулагч зохих журмын дагуу нөхөн төлбөрийг авснаас хойш гарсан хохирлоо буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд даатгуулагч нь нөхөн төлбөрийг даатгагчид бүрэн буцаан төлнө.
- 8.11. Даатгуулагч нөхөн төлбөр авсны дараа даатгалын үлдсэн хугацаан дахь даатгалын үнэлгээг сэргээгээгүй бол дараагийн нөхөн төлбөрийг олгохдоо даатгалын үлдэгдэл үнэлгээг зах зээлийн үнэнд харьцуулж хувь тэнцүүлэн тооцно.
- 8.12. Даатгуулагч нөхөн төлбөр авсан тохиолдолд гэрээний хугацаанд даатгалын үнэлгээ тухайн хэмжээгээр буурах бөгөөд Даатгагчтай харилцан тохиролцсон бол зохих хураамжийг төлсний үндсэн дээр даатгалын үнэлгээг дахин сэргээж болно.
- 8.13. Талууд нөхөн төлбөрийг урьдчилсан байдлаар харилцан тохиролцон түүнээс тодорхой хувийг нь нөхөн төлбөр эцсийн байдлаар тогтоогдохоос өмнө даатгуулагчид олгож болно.
- 8.14. Даатгагчтай тохиролцолгүйгээр даатгалын зүйлийг нөхөн сэргээсэн зардал нь нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох үндэслэл болохгүй.
- 8.15. Даатгуулагч нь аж ахуй нэгж бол Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 11.1.6 -д заасны дагуу олгохоор тооцсон нөхөн төлбөрөөс 10% татварыг суутган тооцно.

- 8.16. Хохирол бууруулах зардлын хэмжээ нь нийт олгохоор шийдвэрлэх нөхөн төлбөрийн 20 хувиас хэтрэхгүй;

ЕС. ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

- 9.1. Дараах тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах. Үүнд:
- 9.1.1. Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлсэн;
 - 9.1.2. Даатгуулагч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
 - 9.1.3. Даатгалын тохиолдол болсныг нотлох боломжгүй, даатгалын гэрээнд тусгагдаагүй шалтгаан, эрсдэлийн улмаас учирсан хохирол;
 - 9.1.4. Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн буюу нөхөн төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан;
 - 9.1.5. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл;
 - 9.1.6. Даатгалын тохиолдлын үед эрсдэлийг таслан зогсоох арга хэмжээ аваагүй буюу хохирлыг санаатайгаар ихэсгэсэн нь тогтоогдсон бол (Эрсдэлийг бууруулах, таслан зогсоох арга хэмжээ авах боломжгүй нөхцөл байдал үүссэн, эсхүл энэхүү арга хэмжээг авснаар өөрт учрах хохирол нь эрсдэлээс учирч болох хохирлоос их болох нь илэрхий байвал энэ заалт хамаарахгүй);
 - 9.1.7. Гэрээнд өөрөөр заагаагүй бол нэмэлт эрсдэлийн улмаас үүдэн гарсан хохирол, нэмэлт зардал;
- 9.2. Дараах тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг олгохоос татгалзах.
- 9.2.1. Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна үүссэн хохирол;
 - 9.2.2. Даатгуулагч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол;
 - 9.2.3. Гэрээнд өөрөөр заагаагүй бол хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн алдагдал;
 - 9.2.4. Даатгалын эрсдэлийн улмаас даатгалын зүйлийн байршиж буй газар, шороо, хөрс, агаар, газрын хэвлийн болон байгаль орчинд учирсан хохирол;
 - 9.2.5. Даатгалын зүйлийг гэмт хэргийн зорилгоор болон хууль бусаар ашиглаж явсан үед учирсан хохирол;
 - 9.2.6. Байлдааны зэвсэг хэрэглэх, атомын, цөмийн, болон цацраг идэвхт эрсдэлүүдээс үүссэн хохирол;
 - 9.2.7. Ажил хаялт, нийгмийн эмх замбараагүй байдал, иргэний бослого, үймээн, гэмт халдлага, дайн, дайны шинжтэй тэмцэл, хувьсгал, маргаан, булаан эзлэх, барьцаалах, баривчлан саатуулах, тэсрэх бөмбөг дэлбэлэх, террорист болон улс төрийн шинж чанартай үйл ажиллагааны улмаас үүдсэн хохирол;
 - 9.2.8. Даатгалын зүйлийн бүрэн бүтэн байдал хангаагүй, ашиглалтын горимыг зөрчсөн, өөрчилсөн, эд ангийн зориулалт, даац ачаалал хэтрүүлснээс үүссэн хохирол;
 - 9.2.9. Шалган турших зорилгоор эсвэл санаатайгаар ачааллыг хэтрүүлэх болон хэвийн бус байдлыг буй болгосон аливаа тохиолдлоос үүссэн хохирол;
 - 9.2.10. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, сэтгэцийн эмгэг болон эрх зүйн чадамжгүй этгээдийн хийсэн аливаа үйлдлээс үүдэн гарсан аливаа хохирол;
 - 9.2.11. Даатгалын тохиолдлын бус үед зайлшгүй сэргээн засварлахтай холбогдон гарах зардал;
 - 9.2.12. Даатгалын үнэлгээнээс давсан хохирол болон хохирлоос үүдсэн ашиг орлогын алдагдал;
 - 9.2.13. Даатгалын зүйлийн ердийн элэгдэл, материалын хэвийн хорогдол, ууршилт зэрэг тухайн эд хөрөнгө материалын шинж чанараас шалтгаалан гарсан хохирол гэмтэл;
 - 9.2.14. Даатгуулагч даатгагчидтай тохиролцолгүйгээр хохирлыг арилгасан, нөхөн сэргээсэн нь хохирлын бодит үнэлгээг тогтоох, батлах боломжгүй болгосон тохиолдолд хохирлыг нөхөн төлөхгүй;

(D232079001) / Ард даатгал ХК /

- 9.2.15. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлийн зөвшөөрөгдсөн байршил өөрчлөгдсөн, бусдад түрээслэх, барьцаалуулах, зээлдүүлэх, ашиглуулах, тээвэрлэх мөн энэ тухай даатгагчид мэдэгдээгүй үед гарсан хохирол;
- 9.2.16. Даатгалын зүйлд зориулалтын бус болон тусгай зөвшөөрөлгүй тоноглол, төхөөрөмжийг нэмэлтээр суулгаснаас үүдэн гарсан аливаа хохирол, түүний үр дагавар болох нь тогтоогдсон бол;
- 9.2.17. Давагдашгүй хүчин зүйл, нийтийг хамарсан онцгой нөхцөл байдал буюу байгалийн гамшиг, газар хөдлөлтийн улмаас гэрээний нөхцөл биелэгдэх боломжгүй болох тохиолдол;
- 9.2.18. Сэтгэл санааны хохирол;
- 9.2.19. Даатгалын зүйл аливаа эрхийн доголдолтой, хууль бусаар бүрдсэн, олгогдсон, улсын бүртгэлд бүртгэгдсэн нь нотлогдсон, мөн төрийн байгууллагын шийдвэрийн улмаас үүссэн хохирол;
- 9.2.20. Даатгуулагч гэрээнд заасан хугацаанд даатгалын хураамжийг төлөөгүй;

АРАВ. ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ

- 10.1. Талууд гэрээний хугацаанд ажил үүргийн шаардлагаар олж мэдсэн, эзэмшиж, ашиглаж байсан баримт бичиг, мэдээ материал болон Талуудын бизнесийн ашиг сонирхолд шууд болон шууд бус хамааралтай компанийн болоод харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээлэл, даатгалын хэмжээ, төлбөр, тооцоо, бусад үзүүлэлтүүд, байгууллага, хувь хүний нууц, Ноу-Хауг хугацаагүй чанд нууцалж, бусдад дамжуулах, хэвлэн нийтлэхгүй байх үүрэгтэйгээр хадгална.

АРВАН НЭГ. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 11.1. Хэрэв даатгагч энэхүү гэрээний дагуу нөхөн төлбөрийг хугацаанд нь олгоогүй тохиолдолд хоног тутамд олгогдох нөхөн төлбөрийн 0.05 хувьтай тэнцүү хэмжээний алдангийг Даатгуулагчид төлнө.
- 11.2. Даатгалын гэрээг дараах үндэслэлээр цуцална. Үүнд:
 - 11.2.1. Даатгуулагч нь төлбөл зохих даатгалын хураамжийг төлөөгүй тохиолдолд Даатгагч гэрээг өөрийн санаачлагаар цуцлах эрхтэй;
 - 11.2.2. Даатгуулагч даатгалын тохиолдол бий болох нөхцөлийг ихэсгэсэн, энэ талаар шаардлагатай арга хэмжээ аваагүй болох нь тогтоогдсон;
 - 11.2.3. Даатгалтай холбоотой баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, хууль бус баримт бичиг бүрдүүлсэн;
 - 11.2.4. Энэхүү гэрээний нууцлалыг задруулснаас гэрээний аль нэг талын ашиг сонирхолд хохирол учирсан буюу учирч болох нөхцөл байдал бүрдсэн;
 - 11.2.5. Даатгагчийн санхүүгийн чадавх илт буурсан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тодорхойлогдсон;
- 11.3. Даатгалын гэрээ цуцлагдсанаас үүсэх үр дагавар
 - 11.3.1. Гэрээний аль нэг тал энэхүү гэрээний нууцлалыг задруулсны улмаас гэрээний нөгөө талд хохирол учирсан тохиолдолд учирсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
 - 11.3.2. Даатгагчийн санаачлагаар гэрээг хугацаанаас өмнө цуцлахад хүрвэл даатгуулагчийн төлсөн хураамжийг бүрэн хэмжээгээр Даатгуулагчид буцаан төлнө. Хэрэв, даатгалын нөхөн төлбөр олгосон байх үед даатгагчийн санаачлагаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд даатгалын нийт хураамжаас ашигласан хугацааны хураамж болон гэрээтэй холбоотой гарсан зардлыг хасаж үлдэх хэсгийг даатгуулагчид эргүүлэн олгоно.
 - 11.3.3. Даатгуулагчийн санаачлагаар гэрээг цуцалбал даатгалын нийт хураамжаас ашигласан хугацааны хураамж болон гэрээтэй холбоотой гарсан зардлыг хасаж, үлдэх хэсгийг даатгуулагчид эргүүлэн олгоно. Хэрэв, даатгалын нөхөн төлбөр олгосон байх үед

(D232079001) / Ард даатгал ХК /


- даатгуулагчийн санаачлагаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд талууд биелэгдсэн үүргийн гүйцэтгэлийг харилцан бие биедээ бүрэн хэмжээгээр буцаан нөхөн төлнө.
- 11.3.4. Гэрээний аль нэг тал энэхүү гэрээнээс үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаан байгаа тохиолдолд гэрээнээс татгалзах тухай бичгэн мэдэгдлийг нэг сарын өмнө нөгөө талдаа өгнө. Гэрээний аль нэг тал гэрээнээс үндэслэлгүйгээр татгалзсанаас нөгөө талд учирсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 11.3.5. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эсхүл талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэрээг хүчин төгөлдөр болгох, гэрээний хугацааг үргэлжлүүлэх, сунгах, гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах боломжгүй нөхцөл байдлыг гэрээнээс татгалзах үндэслэл гэж үзнэ.

АРВАН ХОЁР. БУСАД ЗҮЙЛ


- 12.1. Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол улсын хууль тогтоомжид заагдсан эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.
- 12.2. Маргаан шийдвэрлэх: Талууд энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа асуудал, маргааныг Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү гэрээ болон гэрээний талуудын эрх тэгш байдлын үндсэн дээр аль болох эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд хэрэв талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.
- 12.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах: Талууд харилцан тохиролцож гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гагцхүү бичгээр үйлдэж гарын үсэг зурж, гэрээнд хавсаргаснаар хүчин төгөлдөр болно.
- 12.4. Харилцаа холбооны хэлбэр: Талууд энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа харилцааг гэрээнд дурдсан хаягаар хандаж албан ёсоор хүргүүлэх, шуудан, факс эсхүл цахим мэйл ашиглан бичгээр гүйцэтгэнэ. Ингэхдээ мэдээлэл хүргүүлж буй талын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурсан байна.
- 12.5. Энэхүү гэрээг 9 хуудас бүхий 2 хувь үйлдсэн бөгөөд гэрээний эх хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна.

ТУСГАЙ НӨХЦӨЛ

Даатгагчийг төлөөлж:


/Салбарын даатгалын менежер/

Даатгуулагчийг төлөөлж


/Нягтлан бодогч/

БҮЛЭГ -1

ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛ

Даатгалын зүйл:	Найнги ХХК ажилчид /Хавсралт №1/
Даатгуулагчийн хаяг:	Даатгалын зүйл нь Монгол улсад байдаг бөгөөд Дорнод аймагт -д харьяалагдана.
Даатгалын нийт үнэлгээ:	112,000,000төгрөг
Даатгалын хураамжийн хувь:	1%
Даатгалын нийт хураамж:	1,120000 төгрөг
Нийт даатгуулагчийн тоо:	56
Нэг даатгуулагчийн үнэлгээ:	/Хавсралт №1/
Нэг удаагийн тохиолдолд хүлээх хариуцлагын хязгаар:	20,000 төгрөг хүртэл
Даатгуулагчийн хүлээх хариуцлага:	Нэг удаагийн тохиолдолд даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлага нь: <ul style="list-style-type: none"> ➤ 20,000 .төгрөг байх ба хохирогч нас барсан эсвэл хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тохиолдолд хохирлын 5 хувь байна. ➤ Хүүхэд хүүхдээ зодсон тохиолдолд 20% ➤ Бусдад зодуулж дээрэмдүүлсэн тохиолдолд 10% ➤ Даатгуулагчид харилцан зодолдсон тохиолдолд тус бүр 30% ➤ Дугуйт тэшүүр, тэшүүр, унадаг дугуй, цана, чарга, усан сан гэх мэт спортын тоглоомоос үүдэлтэй өөрийн анхаарал болгоомжгүй байдлаас үүссэн хохиролын хувьд 10% байна.
Даатгалд хамрагдахгүй нөхцөл:	Гэрээний Ерөнхий нөхцөлийн 9 дүгээр бүлэг Гэрээний Тусгай нөхцөлийн 14-т хамаарах заалтууд
Даатгалын хамгаалалт үйлчлэх хугацаа:	24 цаг
Даатгалын гэрээний хугацаа:	1 жил буюу 365 хоног

ТУСГАЙ НӨХЦӨЛ

АРВАНГУРАВ, ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛ

- 13.1 Энэхүү даатгалын хэлбэрт хэрэглэгдэх нэр томъёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:
- 13.1.1 **Даатгагдсан этгээд** гэдэгт даатгалын тохиолдол болсноор энэхүү гэрээний дагуу амь нас, эрүүл мэндээр хохирсон иргэн, хувь хүнийг;
- 13.1.2 **Гэнэтийн осол** гэдэгт гэнэтийн, гадны хүчний нөлөөгөөр бие махбодод гэмтэл, бэртэл учруулах гэнэтийн тохиолдол болсон нөхцөл байдлыг;
- 13.1.3 **Нас баралт** гэж даатгагдсан этгээдийн гэнэтийн осолд орсоноос хойш 12 сарын дотор тухайн ослын үр дагаврын улмаас нас барах тохиолдлыг;
- 13.1.4 **Хөдөлмөрийн чадварын түр алдалт** гэдэгт даатгуулагч буюу даатгагдсан этгээдийн гэнэтийн осолын улмаас эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн болон байнгын амбулаторийн хяналтанд байсан хуанлийн 90 хүртэлх хоногийг;
- 13.1.5 **Хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдах** гэж даатгуулагч буюу даатгагдсан этгээд гэнэтийн ослын улмаас эмнэлэг, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөдөлмөрийн чадвараа 70 хувь хүртэл алдахыг;
- 13.1.6 **Хөдөлмөрийн чадвар бүрэн алдалт** гэж даатгуулагч буюу даатгагдсан этгээд гэнэтийн ослын улмаас эмнэлэг, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөдөлмөрийн чадвараа 71 буюу түүнээс дээш хувиар алдахыг;
- 13.1.7 **Ашиг сонирхол бүхий этгээд** гэж даатгалын тохиолдол бий болсон үед энэхүү гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөрийг хүлээн авах эрх бүхий хувь хүн, хуулийн этгээдийг;
- 13.1.8 **Зөвхөн ажил үүргээ биелүүлж явах үеийн** гэж даатгуулагч буюу даатгагдсан этгээд хөдөлмөрийн болон бусад адилтгах гэрээний дагуу ажил хөдөлмөр эрхэлэх, гүйцэтгэх, байгууллагын зохион байгуулалттай ажилд, тэмцээнд оролцох, томилолтод явах, ажилдаа явах, буцах шууд замд байгаа үеийг хэлнэ;
- 13.1.9 **24 цагаар** гэж даатгуулагч буюу даатгагдсан этгээд зөвхөн ажил үүргээ биелүүлж явах үеээс гадна хувийн бусад ажил, амралтын бусад бүх цаг үеийг;
- 13.1.10 **Үйлдвэрлэлийн осол** гэж даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн нөлөөлөлд өртөхийг;
- 13.1.11 **Хордлого** гэж нянгийн хор, хүнд металл, пестицид, хортой ургамал, амьтан, органик болон органик бус нэгдэл, ионжуулагч туяа цацрагаар бохирдсон хоол хүнс, бүтээгдэхүүн, усыг хэрэглэснээс үүссэн эмгэг мөн богино хугацаанд цацраг идэвхт буюу химийн бодисын нөлөөгөөр хордохыг;
- 13.1.12 Гэнэтийн ослын даатгалын зүйл гэдэгт Монгол улсын иргэд болон гадаадын харьяат иргэдийг хамруулна.
- 13.2 Гэнэтийн ослын даатгалын үнэлгээ, хураамж, даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагын хэмжээ, хураамж төлөх хугацааг Ерөнхий мэдээлэл (Schedule)-д заавал тэмдэглэж энэхүү гэрээнд тусгана.
- 13.3 Даатгагдсан зүйлсийн талаархи дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралтаар гарган энэхүү гэрээнд хавсаргана.
- 13.4 Гэнэтийн ослын даатгалын эрсдэл:
- 13.4.1 Бүх төрлийн гэнэтийн осол буюу тодруулбал:
- 13.4.1.1 Байгалийн эрсдэл; (хүчит салхи, цас, цасан ба шороон шуурга, ган, зуд, цочир хүйтрэлт, үер, газар хөдлөлт, хөрс, чулууны нуралт, цөмрөлт, хүйтэн бороо, аянга, мөндөр, хяруу, ой хээрийн түймэр, ус, шаварт унаж шигдэх, хөлдөх, осгох, наранд цохиулах зэрэг) эрсдэл;
- 13.4.1.2 Галын эрсдэл; (гал, түймэр, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлт)

- 13.4.1.3 Гадны нөлөөлөл; (бусдад хорлогдох, зодуулах, дээрэмдүүлэх, буу мэс зэрэг зэвсэгтэй дайралтанд өртөх, нохойд хазуулах, мөргүүлэх, шидэгдэх, унах, хавчуулах, дээрээс нь юм унах, унаж бэртэх, хальтрах, зам тээврийн аюул осолд өртөх, түлэгдэх, угаартах, элдэв хорт хий, хоол, эмийн зүйлээс хордох, малд дайруулах мөргүүлэх, өшиглүүлэх, тийрүүлэх, хазуулах) эрсдэл

АРВАНДӨРӨВ. ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- 14.1 Даатгагдсан этгээдэд даатгалын тохиолдлын улмаас хохирол учирсан бол дараах нөхцөлүүдийг харгалзан даатгалын нөхөн төлбөрийг олгоно. Үүнд:
- 14.1.1 Даатгагчийн даатгалын хугацаанд олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ нь гэрээнд заасан даатгалын үнэлгээгээр хязгаарлагдана.
- 14.1.2 Тухайн нэхэмжлэлээр нэг хүний эрүүл мэндэд учирсан хохиролд олгож болох дээд хэмжээ нь даатгалын нэг удаагийн тохиолдлоор нэг хүнд ногдох даатгалын үнэлгээтэй тэнцүү байна.
- 14.1.3 Даатгагч нь учирсан хохирлыг даатгуулагчийн нэрийн өмнөөс нөхөн олгохдоо Монгол улсын шүүхийн шийдвэр, эрх бүхий байгууллагын хохирлын хэмжээг тогтоосон хохирлын актыг үндэслэн тус тус тооцож хохирлыг барагдуулна.
- 14.1.4 Олгохоор тооцсон нөхөн төлбөрөөс даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагын дүнг хасч олгоно.
- 14.1.5 Даатгагчаас даатгуулагчид олгох нөхөн төлбөр болон хохирол бууруулах үйл ажиллагааны зардлын нийлбэр нь даатгалын нэг удаагийн тохиолдлоор хүлээх хариуцлагын хязгаараас хэтэрч үл болно.
- 14.1.6 Даатгуулагчийн ажилтны амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг хохирогчийн нэхэмжлэлийн талаар гаргасан шүүхийн шийдвэр болон дотоодын эмчилгээ үйлчилгээний тарифаар тооцсон баримтаар нотлогдох эмчилгээ үйлчилгээний зардлын дүнгээр даатгалын нэг удаагийн тохиолдолд тухайн даатгагдсан этгээдийн даатгалын үнэлгээний 20 хувиас хэтрэхгүй нөхөн олгоно.
- 14.1.7 Нөхөн төлбөр олгох нотолгоо баримт бүрдүүлээгүй бол нөхөн төлбөрийг дараах байдлаар тооцож олгоно. Үүнд:
- 14.1.7.1 Даатгалын эрсдэлийн улмаас хохирогч этгээд нас барах, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдах тохиолдолд даатгалын нэг удаагийн тохиолдлоор нэг хүнд ногдох даатгуулсан хариуцлагын хязгаарт багтаан 100 хувиар нөхөн төлбөр олгоно.
- 14.1.7.2 Даатгагдсан этгээд нь хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол түүний эмнэлэгт хэвтсэн, амбулатори болон гэрээр эмчлүүлсэн (Холбогдох эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг үндэслэн) хуанлийн өдрөөр тооцсон хугацаанаас хамааруулан дор дурьдсан хувиар хариуцлагын хязгаараас бодож нөхөн төлбөр олгоно. Үүнд:
- а) 90 хүртэл хоногийн хугацаагаар эмчлүүлсэн хуанлийн хоног тутамд даатгалын үнэлгээний 0.3 хувь;
- б) 91 хоногоос дээш хугацаагаар эмчлүүлэх шаардлагатай буюу хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн эсвэл бүрэн алдсан бол а)-д заасан нөхөн төлбөр дээр даатгуулсан хариуцлагын дүнгээс дараах хувиар нөхөн төлбөр тооцож нэмж олгоно. Үүнд:
- б.1 Хөдөлмөрийн чадвараа 30 хувь алдсан бол үнэлгээний 20 хувь
- б.2 Хөдөлмөрийн чадвараа 31-50 хувь хүртэл алдсан бол үнэлгээний 30 хувь
- б.3 Хөдөлмөрийн чадвараа 51-70 хувь хүртэл алдсан бол үнэлгээний 50 хувь
- б.4 Хөдөлмөрийн чадвараа 71 буюу түүнээс дээш хувиар алдсан бол үнэлгээг 100 хувь

- 14.1.8 Даатгуулагч гэнэтийн ослоор нас барсан тохиолдолд даатгалын үнэлгээний 100 хувиар тооцож нөхөн төлбөр авах ба нийт олгох нөхөн төлбөр нь даатгалын үнэлгээнээс хэтрэхгүй байна
- 14.1.9 Нөхөн төлбөрийг эмчилгээний хугацаа дууссаны дараа эсхүл хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн болон бүрэн алдсанаа тогтоолгосон тухай шийдвэр гарсаны дараа нөхөн төлбөрийг тооцож олгоно.
- 14.2 Тухайн даатгалын онцлогтой холбоотой дараах тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг олгохоос татгалзана. Үүнд:
- 14.2.1 Эд хөрөнгөнд учирсан аливаа хохирол;
- 14.2.2 Даатгуулагч байгууллагатай хөдөлмөрийн буюу ажил гүйцэтгэх гэрээгүй хүний аливаа хохирол;
- 14.2.3 Даатгуулагч даатгагчидтай тохиролцолгүйгээр хохирлыг арилгасан нь хохирлын бодит үнэлгээг тогтоох, батлах боломжгүй болгосон тохиолдолд хохиролыг нөхөн төлөхгүй;
- 14.2.4 Гуравдагч этгээдэд түүнчлэн бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулсан хохирол, хохирол учирсаны төлөө хүлээх хариуцлага
- 14.2.5 Даатгуулагчийн бусдын жор, патент, лиценз гэрчилгээний эрхийг зөрчсөнөөс үүссэн хохирол;
- 14.2.6 Даатгуулагчийн ажилтан нь хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэвэл зохих хугацаанд дур мэдэн өөр ажил гүйцэтгэх болон ажлын байраа орхиж яваад, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсний болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг санаатай зөрчсөний улмаас учирсан хохирол;
- 14.2.7 Даатгуулагч хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны журмыг илтэд зөрчсөн тохиолдолд учирсан хохирол;
- 14.2.8 Даатгуулагчийн өөрийн эрүүл мэндээс шалтгаалан гарсан хохирол;
- 14.2.9 Даатгуулагч нь даатгалд хамрагдахаас өмнө учирсан ослын улмаас олсон гэмтлийн урхаг, хор нөлөөг эдгэрүүлэх, сэргийлэх зорилгоор дахин эмчилгээ хийлгэж эмнэлэгт хэвтсэн, амбулатори болон гэрээр эмчлүүлсэн бол;
- 14.2.10 Мэргэжлийн спортын, уралдаан тэмцээн мөн бүхий л дотоод шаталтын хөдөлгүүртэй тээврийн хэрэгслэлээр уралдаан тэмцээнд оролцсон, уулын спорт, агаарын бүхий л спорт болон шүхрийн спортод оролцсон бол/**Энэ хэсгийг даатгалын нөхөн төлбөр олгохгүй нөхцөлөөс хасав. Байгууллага болон Мэргэжлийн удирдах шатны байгууллагаас оролцох тэмцээн уралдаанд оролцох үед гэнэтийн ослыг олгохоор болов.**/
- 14.2.11 Даатгуулагч сэтгэл санааны хямрал, сэтгэцийн эмгэг, эрх зүйн чадамжгүй үе, саа өвчний улмаас болон түр зуурын шокийн байдлаас үүдсэн гэмтэл бэртэл болон согтууруулах ундаа мөн мансууруулах бодис хэрэглэснээс үүдсэн хохирол;
- 14.2.12 Даатгуулагчийн ажил мэргэжлээс шалтгаалах өвчин болон удаан хугацааны туршид үүссэн нуруу нугасны гэмтэл;
- 14.2.13 Ердийн болон халдварт өвчний улмаас хэвтэж эмчлүүлсэн тахир дутуугийн зэрэглэл тогтоолгосон болон рашаан сувилалын амралтын газар сувилуулж, эмчлүүлсэн бол;
- 14.2.14 Даатгуулагч нь санаатайгаар өөрийн биед гэмтэл учруулсан, амиа хорлосон, амиа хорлохыг завдсан бол;
- 14.2.15 Даатгуулагч нь эрүүгийн гэмт хэрэг үйлдэж байхдаа болон үйлдэхийг завдсан үед учирсан хохирол;
- 14.2.16 Цалин хөлс, тэтгэвэр, бусад томилолтын зардал;
- 14.2.17 Мэргэжлийн нарийн ур чадвар туршлага шаардагдах ажилд туршлагагүй ажилтныг томилон ажиллуулснаас үүдсэн хохирол.
- 14.2.18 Даатгуулагчийн 90-ээс дээш хоногт эмчлүүлснийн төлбөр;
- 14.2.19 Нөхөн төлбөр хүссэн баримт, материалуудыг даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуанлын 180 хоногоос дээш хугацаагаар хожимдуулсан тохиолдолд даатгуулагч нөхөн төлбөр нэхэмжлэх эрхээ алдана.

14.3 Даатгуулагчийн хүлээх тусгай үүрэг:

- 14.3.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэлд гарсан өөрчлөлтийг цаг тухайд нь даатгагчид мэдэгдэх
- 14.3.2 Даатгалын тохиолдлоор хүний амь нас хохирсон бол энэ тухай даатгагчид 48 цагийн дотор урьдчилан мэдэгдэх (утас, и-мэйл, албан бичиг гэх мэт аль боломжтой арга хэлбэрээр);
- 14.3.3 Хөдөлмөр хамгаалалтын улсын норм стандартыг мөрдөх;
- 14.3.4 Даатгуулагч түүнчлэн гэрээ байгуулснаас хойш бий болсон ажил мэргэжлийн өөрчлөлт болон даатгалын тохиолдол бий болох нөхцөл орчин бүрдсэн тухай даатгагчид нэн даруй мэдээлэх;

БАТЛАВ.
"ЧОЙБАЛСАН ХӨГЖИЛ" ОНӨҮГ
ЗАХИРАЛ /Б. ГЭРЭЛТ-ОД/

БАТЛАВ.
"НАЙНГИ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /Ш.БЯМБАСҮРЭН/

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2023 оны 01 сарын 03 өдөр.

Хэрлэн сум

Нэг талаас "Чойбалсан Хөгжил" ОНӨҮГ (цаашид "А" тал гэнэ), түүнийг төлөөлж тооцооны нягтлан бодогч ажлын туслах Ц.Болорцэцэг Нөгөө талаас НАЙНГИ ХХК /РД:2010895/ түүнийг төлөөлж байгаль орчны ажилтан Энхтүвшин овогтой Төмөрбаатар (цаашид "Б" тал гэнэ), түүнийг төлөөлж бид дараахь нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

1. "А", "Б" талын нийтлэг үндэслэл

1.1. "А", "Б" талууд нь хүний эрүүл мэнд хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх хоггүй цэвэр орчинд ажиллаж, амьдрах зорилгоор тогтоосон хуваарийн дагуу хаягдал хогийг цуглуулан тээвэрлэж тогтоосон түр цэгт хадгалах ба аюулгүй орчинд зөөж тээвэрлэхэд хамтран ажиллана.

1.2. Гэрээний хугацааг "А", "Б" талууд 2023 оны 01 сарын 03-ны өдрөөс 2023 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл байгуулав. Гэрээний хугацааг талууд тохиролцон сунгаж болно.

2. "А", "Б" талын хамтын ажиллагааны удирдлага, хяналт

- 2.1. "А", "Б" тал нь гэрээний хэрэгжилт болон талуудын гэрээний талаархи үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.
- 2.2. Талууд аль нэг талынхаа шаардсан үед хамтын ажиллагаатай холбоотой өөрийн хийсэн ажлын талаар тайлагнана.

3. Нэг. "А", "Б" талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг

- 3.1. "Б" тал нь гэрээнд заагдсан хэмжээ, хугацаанд хог хаягдлыг тээвэрлүүлнэ.
- 3.2. "Б" тал нь хог хаягдлын хураамж 7м3 /70000 төгрөг/ төгрөгийг "А" талд талоноор олгоно.
- 3.3. "А", "Б" тал нь "Хог хаягдлын тухай" хуулийн 10 дугаар зүйлийг мөрдлөг болгон ажиллана.
- 3.4. "Б" тал нь "А" талд хог хаягдлын хураамжыг төлөөгүй тохиолдолд хог хаягдлыг тээвэрлэхгүй.
- 3.5. "А" тал хог хаягдлыг гэрээнд заагдсан хугацаанд аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тусгай тоногдсон автомашинаар тээвэрлэнэ.
- 3.6. "А" тал нь "Б" талын хог хаягдлыг сард дуудлагаар ачиж тээвэрлэнэ.

4. Маргааныг шийдвэрлэх

4.1. Гэрээгээр хүлээсэн үүрэгтэй холбоотой асуудлаар 2 тал харилцан зөвшилцөн, тохиролцоонд хүрээгүй тохиолдолд холбогдох хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

5. Бусад заалт

5.1. "А", "Б" талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, бусад

хууль тогтоомжийг удирдлага болгоно.

- 5.2. Хог хаягдлыг тээвэрлэхтэй холбоотой санал, хүсэлтийг байгууллагын 70582832 дугаарын утас болон "А" талд албан бичгээр мэдэгдэх.
- 5.3 "Б" тал нь хог хаягдлыг зориулалтын хогны саванд хийж байршуулна.
/Галд шатахгүй, орчин бохирдуулахгүй байх/

6. Гэрээ хүчин төгөлдөр байх

- 6.1. "А", "Б" талууд нь гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хүчин төгөлдөр болно.
- 6.2. Гэрээг хуульд зааснаас бусад тохиолдолд талууд (дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно) харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас өмнө ажлын 10 хоногийн дотор урьдчилан мэдэгдэх замаар гэрээг цуцалж болно. Энэ тохиолдолд шалтгааныг тодорхой бичин албан тоотоор хандана.
- 6.3. Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7. Талуудын хаяг

А" тал:

Хаяг: Хэрлэн сум 2-р баг
"Чойбалсан хөгжил" ОНӨҮГазрын
Тооцооны нягтлан бодогч *Ц.Болорцэцэг*
Утас: 70582832

"Б" тал:

Хаяг: Хэрлэн сум
Найнги ХХК
Э.Төмөрбаата
Байгаль орчины ажилтан
Утас: 88405655

БАТЛАВ.
"НАЙНГИ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ /Ш.БЯМБАСҮРЭН/

БАТЛАВ.
"ЧОЙБАЛСАН ХӨГЖИЛ" ОНӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ /Б.ГЭРЭЛТ-ОД/

ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022.12.01

№

Чойбалсан хот

Нэг талаас: "НАЙНГИ" ХХК (Цаашид "Нийлүүлэгч" гэх), түүнийг төлөөлж механикч М.Бямба-Наран

Нөгөө талаас: "Чойбалсан хөгжил" ОНӨҮГ цаашид ("Хүлээн авагч" гэх), түүнийг төлөөлж механикч Б.Мөнхбаяр энэхүү гэрээг дараахь нөхцөлөөр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Нийлүүлэгчийн 2022-2023 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн агаар, хөрс, усанд сөрөг нөлөөлөл үзүүлэх аюултай хог хаягдал ажилласан тос, маслыг Хүлээн авагчийн ахуйн хэрэгцээнд дахин ашиглуулахаар хүлээлгэн өгөх, хүлээн авахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү гэрээ нь 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний талууд харилцан тохиролцож сунгаж болно.

Хоёр. Гэрээний нөхцөл, хамтын ажиллагаа

- 2.1 Хамтран үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон дараахь арга хэмжээг талууд гүйцэтгэнэ. Үүнд:
 - 2.1.1 "Чойбалсан хөгжил ОНӨҮГ" ахуйн хэрэглээнд дахин ашиглах техникийн ажилласан тос, маслыг хэрэглэх хэмжээг урьдчилан мэдэгдэнэ.
 - 2.1.2 "Найнги" ХХК холбогдох дүрэм, журам, стандартад нийцүүлэн хүссэн хэмжээгээр хүргэж өгч ажиллана.
- 2.2 Хагас жилээр нийлүүлсэн, хүлээн авсан аюултай хог хаягдлын хэмжээгээр тайлан гаргаж үр дүнг талууд дүгнэнэ.
- 2.3 Нийлүүлэгч нь үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдлыг нийлүүлэх хүргэж өгөх зардлыг бүрэн хариуцна.

Гурав. Гэрээний хариуцлага, хяналт

- 3.1 Энэхүү гэрээний 1.1-д заасан чиглэл болон хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг дараахь чиглэлээр удирдан явуулна.


- 3.1.1 Хог хаягдлыг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн тэмдэглэл хөтөлнө.
- 3.1.2 Хамтын ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлж буй талууд гэрээний хэрэгжилт болон талуудын гэрээний талаархи үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.
- 3.1.3 “Чойбалсан хөгжил” ОНӨҮГ хаягдал тос, маслыг техникийн тос тосолгоонд зориулалтын дагуу зарцуулсан тухай 6 сард 1 удаа тайлагнах үүрэгтэй.
- 3.1.4 Хүлээн авсан аюултай хог хаягдал ажилласан тос, маслыг бусдад дамжуулах, хөрсөнд асгах, буруу зүйлд зарцуулах зэрэгт **Найнги ХХК** хариуцлага хүлээхгүй.

Дөрөв: Гэрээ хүчин төгөлдөр байх


- 4.1 Талууд гэрээнд гарын үсэг зурж тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.
- 4.2 Талууд тохиролцвол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Нийлүүлэгчийг төлөөлж:

“Найнги” ХХК-ний
Механикч 
/М.Бямбанаран/
Утас 86088628

Хүлээн авагчийг төлөөлж:

“Чойбалсан хөгжил” ОНӨҮГ-ын
Механикч 
/Б.Мөнхбаяр/
Утас: 89683094

НАЙНГИ ХХК-ийн автомашин засварын хэсгээс гарсан
хаягдал тосыг хүлээлгэн өгсөн акт

2023.01.....

№	Хаягдал тосны нэр	Хэмжээ /кг/
1.	Гидрийн шингэн, масло	400
	Нийт	

Дахин ашиглах тос тосолгооны зориулалтаар хүлээлгэн өгөв.

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:

НАЙНГИ ХХК-ийн Байгаль орчны ажилтан



/Э.Төмөрбаатар/

ХҮЛЭЭН АВСАН.

1. Д. Дорнодбаатар 2. Ж. Дорнодбаатар

88369449

W